

Бид амьдарч буй газрынхаа засгийн газрын хуулиудыг дагаж мөрдөхөд итгэдэг

Дараах жишээг унш.

Далиа засгийн газар нь сүмийн байрнаас гадуур сайн мэдээг хуваалцахыг зөвшөөрдөггүй газарт номлолоор үйлчилж байв. Хэрэв Есүс Христийн сайн мэдээний талаар нээлттэй ярьж чадвал хүлээж авах хүмүүс хотод байгаа гэдгийг мэдэж байгаа учраас тэр бухимдаж байв. Тэрээр гудамжинд хүмүүст Аврагчийн тухай заахын тулд тэдэнтэй нууцаар ярилцах тухай бодож байлаа.

- Та нар энэ нөхцөл байдалд хэрхэн хариулах вэ?

Дараах материалуудыг уншаад, эдгээр нь Тэнгэрлэг Эцэг Далиагаас юу хийгээсэй гэж хүсэх байсныг ойлгоход хэрхэн тусалж болох талаар бодож үз.

Сургаал ба Гэрээ 58:21–22

Итгэлийн тунхаг 1:12

1 Тимот 2:1–3

Засгийн газар болон шашны хооронд гарч болзошгүй зөрчилдөөнд Аврагч хэрхэн хариулсныг харахын тулд Матай 22:15–22-ыг болон Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Даллин Х.Өүксийн хэлсэн дараах мэдэгдлийг унш.



Бүх итгэгч тэнгэрлэг хуулийг дээдэлдэг ч иргэний хууль ч бас Бурханаас тогтоогдсон гэдгийг ихэнх нь хүлээн зөвшөөрдөг. Их Эзэн Есүс Христ: “Цезарийн юмыг Цезарьт нь, Бурханы юмыг Бурханд өг” (Матай 22:21) гэж чиглүүлжээ. Тиймээс бид аль болох хуулийн хоёр тогтолцоог хоёуланг нь дагаж мөрдөх ёстой гэж заасан. Илэрхий зөрчилдөөн гарах үед бид тэднийг зохицуулахыг эрэлхийлэх ёстой. Тэд үнэхээр эвлэршгүй байх аваас бид санаа нэгтэйгээр бусад хүнтэй нэгдэж, иргэний хуулийг тэнгэрлэг хуультай нийцүүлэн өөрчлөхийг хичээвэл зохино. Ямар ч тохиолдолд бид шийдвэр гаргахдаа долоо хэмжиж, нэг огтлох ёстой. Хамгийн ховор тохиолдлуудад л нэгийг нь орхиж, нөгөөг нь дэмжинэ. (Dallin H. Oaks, “The Boundary between Church and State” [address given at the Second Annual Sacramento Court/Clergy Conference, Oct. 20, 2015], newsroom. ChurchofJesusChrist.org)

Дараах асуултуудад хариул.

- Та нар үйлчилж буй газрынхаа хуулийг хүндлэх ёстой гэдгийг ойлгоход нь Далиад тусалж болох юуг сурсан бэ?
- Та нар яагаад амьдарч буй газрынхаа хуулийг дагаж мөрдөх нь Есүс Христийн сайн мэдээний нэг зарчим гэж бодож байна вэ?